МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

# ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2020 он

# 1 Монгол Улсын далайн тээврийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

- ОУДБ-ын аудитын шалгалтын зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан
- Монгол Улсын нэгдэн орсон далайн салбарын гэрээ, конвенцыг хэрэгжүүлэх төлөвлөгөө" 2018-2021 он /Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 201 дүгээр тогтоол/
- Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
- "Хөлөг онгоц бүртгэх журам"-ын шинэчилсэн төсөл
- "Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын үйл ажиллагаанд Далбааны эзэн улсаас хяналт тавих журам"-ын төсөл
- "Далайн тээврийн осол, зөрчлийг шинжлэн шалгах журам"ын төсөл
- Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын "Далайн хөдөлмөрийн тухай" 2006 оны конвенцын 2014 оны нэмэлт өөрчлөлтөд Монгол Улс нэгдэн орсон

# 2 Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын чиглэлээр:

*2020.02.01-ны байдлаар

**22** хөлөг онгоцыг шинээр бүртгэж

2019 онд

**190** хөлөг онгоцыг шинээр бүртгэв

**374** хөлөг онгоц идэвхтэй бүртгэлд байна.

- **357** Энгийн бүртгэлтэй
- **15** Нэг удаагийн аяллын бүртгэлтэй
- **2** Хөлөг онгоц дангаар түрээслэх бүртгэлтэй



# 2 Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын чиглэлээр:

| № | Улс | Хөлөг онгоцны тоо | Хувиар /%/ |
|---|---|---|---|
| 1 | Singapore | 96 | 25.67 |
| 2 | Malaysia | 61 | 16.31 |
| 3 | Hong Kong | 47 | 12.57 |
| 4 | Indonesia | 18 | 4.81 |
| 5 | Panama | 16 | 4.28 |
| 6 | Marshal Islands | 15 | 4.01 |
| 7 | Taiwan | 13 | 3.48 |
| 8 | Japan | 12 | 3.21 |
| 9 | BVI | 11 | 2.94 |
| 10 | China | 11 | 2.94 |
| 11 | Seychelles | 11 | 2.94 |
| 12 | Vietnam | 11 | 2.94 |
| 13 | UAE | 8 | 2.14 |
| 14 | Belize | 7 | 1.87 |
| 15 | UK | 7 | 1.87 |
| 16 | Malta | 5 | 1.34 |
| 17 | Philippines | 5 | 1.34 |
| 18 | Anguilla | 3 | 0.80 |
| 19 | India | 2 | 0.53 |
| 20 | Korea | 2 | 0.53 |
| 21 | Samoa | 2 | 0.53 |
| 22 | Suriname | 2 | 0.53 |
| 23 | Bangladesh | 1 | 0.27 |
| 24 | Cambodia | 1 | 0.27 |
| 25 | Greece | 1 | 0.27 |
| 26 | Leberia | 1 | 0.27 |
| 27 | Qatar | 1 | 0.27 |
| 28 | Russia | 1 | 0.27 |
| 29 | Spain | 1 | 0.27 |
| 30 | Thailand | 1 | 0.27 |
| 31 | Turkey | 1 | 0.27 |
| Нийт | | 374 | 100 |



# 2 Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын чиглэлээр:

## Хөлөг онгоцны бүртгэлд зуучлах агенттай байгуулсан гэрээ:

- БНТУ-ын “Rayah Maritime Survey Services Foreign Trade” ХХК
  2019 оны 12 дугаар сарын 19

**ГАРЫН ҮСЭГ**

Гэрээний эхэнд тусгагдсан өдөр үйлдсэн болохыг ГЭРЧЛЭН:

| МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААГ ТӨЛӨӨЛЖ: | ЗУУЧЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| Далайн захиргааны дарга | “Раяах Мэритайм Сурвей Сервис Форейн Трейд” ХХК-ийн |
| Саранжавын Түвшинтөр | Радван Яхья / Ерөнхий менежер |
| /Байгууллагын регистрийн дугаар: 5292816/ | /Байгууллагын регистрийн дугаар: 934965/ |

- АБНЕУ-ын “Pharaohs Marine Consultants” ХХК
  2019 оны 12 дугаар сарын 25

**ГАРЫН ҮСЭГ**

Гэрээний эхэнд тусгагдсан өдөр үйлдсэн болохыг ГЭРЧЛЭН:

| МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААГ ТӨЛӨӨЛЖ: | ЗУУЧЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| Далайн захиргааны дарга | “Фараонс Марин Консалтантс” ХХК-ийн |
| Саранжавын Түвшинтөр | Мохамед Тахоун / Гүйцэтгэх захирал |
| /Байгууллагын регистрийн дугаар: 5292816/ | |

# 2 Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын чиглэлээр:

Хүлээн зөвшөөрөгдсөн 16 байгууллагатай хамтран ажиллаж байна.

- Lloyd's Register (LR)
- Korean Register of Shipping (KRS)
- International Register of Shipping (IS)
- Russian Maritime Register of Shipping (RMRS)
- SingClass International (SCI)
- Sing Lloyd (SGL)
- Indian Register of Shipping (IRS)
- VietNam Register (VR)
- Foresight Ship Classification (FSCLASS)
- Cosmos Marine Bureau (CMB)
- International Marine Survey Association (IMSA)
- Turkish Lloyd (TL)
- PT Biro Klasifikasi Indonesia (BKI)
- China Corporation Register of Shipping (CCRS)
- Aegean Register of Shipping (CLASSARS)
- Asia Shipping Certification services

# 2 Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын чиглэлээр:

## Далбааны эзэн улсын хяналт шалгалт:

2019 онд Монгол Улсын далбаатай нийт 7 хөлөг онгоцонд Далбааны эзэн улсын үзлэг, шалгалт хийлээ.













| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Хөлөг онгоцны нэр | MORAY | SINBAD | ALADIN | ASIA STAR | LANG MAS III | ZHI MING | GENESIS |
| IMO* дугаар | 9123879 | 7932006 | 6524230 | 9405136 | 8622854 | 7302548 | 7217092 |
| Бохир/цэвэр даац | 7463/4680 | 375/167 | 625/216 | 2988/1799 | 499/199 | 655/344 | 648/334 |
| Үйлдвэрлэгдсэн он | 1996 | 1981 | 1965 | 2005 | 1984 | 1973 | 1972 |
| ХЗБ** | Сингкласс | Сингкласс | Сингкласс | Синглойд | Сингкласс | FSC | Сингкласс |

# 2 Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын чиглэлээр:

Далбааны эзэн улсын хянан шалгагчийг мэргэшүүлэх ажлын хүрээнд:




БНХАУ-ын Шанхай хотод тус улсын Хөлөг онгоцны техникийн ангилалын нийгэмлэгээс ОУДБ-тай хамтран 2019 оны 10 дугаар сарын 13-25-ны өдрүүдэд зохион байгуулсан “Хөлөг онгоцны үзлэг шалгалтын технологи, менежментийн талаарх сургалт”-ад далбааны эзэн улсын хяналтын байцаагчийг хамруулав.

# 2 Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын чиглэлээр:




Хөлөг онгоцны байршил тогтоох, алсын зайнаас хянах системийн хэрэгжүүлэх зориглоор ИБУИНВУ-ын “Fulcrum Maritime Systems” компанитай хамтран ажиллах гэрээг 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж эхлээд байна.

# 3 Далайн тээвэр, боомт ашиглалтын чиглэлээр:




***Тайлбар: Чингэлэг тээврийн хөлөг онгоц /ФЭСКО НОВИК/ 707 TEU даацтай.***
*Монгол Улс нь нэг сард импортоор дунджаар БНСУ-аас 400-800 TEU чингэлэг тээвэрлэгддэг байна.*

## 2019 онд хийсэн судалгаа:

- “БНСУ-аас Монгол Улсад чингэлгээр тээвэрлэгдэж буй импортын бараа бүтээгдэхүүнийг “Монгол-Саммок Ложистик” хамтарсан компаниар дамжуулан тээвэрлэх нөхцөл боломжийн талаарх судалгаа”
- “Олон Улсын байгууллагууд болон тэдгээрээс батлан гаргасан Монгол Улсын тээвэр, логистикийн салбарт ээрэг нөлөө үзүүлж болох эрх зүйн баримт бичиг, хөтөлбөрийн судалгаа”
- “Монгол Улсын экспортын коксжих нүүрсийг БНХАУ-ын далайн боомт (Цаофэйдянь боомт болон Жинжоу боомт) хүргэж худалдаалах эдийн засгийн тооцоо судалгаа”
- “Хуурай боомтын талаарх ойлголт болон бусад улсын туршлагыг Монгол Улсад ашиглах нь” судалгаа

# 3 Далайн тээвэр, боомт ашиглалтын чиглэлээр:

ОХУ-ын Владивосток хотод 2020 оны 9 дүгээр сарын 4-6 өдрүүдэд “Дорнын эдийн засгийн форум болов.”






Монгол Улсын Ерөнхийлөгчийг Алс дорнодын эдийн засгийн V чуулганд оролцох үер ОХУ-ын FESCO компанийн зүгээс Зарубино боомт дээр нүүрсний терминал байгуулах замаар далайн тээврийн салбарт хамтран ажиллах зорилгоор гаргасан “Төслийн өмнөх ажлын зураглал”-д үндэслэн Зарубино боомтын төслийг судлаж, боомттой холбоотой эдийн засгийн үр ашгийн талаарх дүгнэлтийг боловсруулан ЗТХЯ-нд хүргүүлэв.

# 3 Далайн тээвэр, боомт ашиглалтын чиглэлийн хамтын ажиллагаа:

Далайн захиргаанаас Тээвэр, логистиктой холбоотой хийсэн судалгааны ажлын хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох семинарт илтгэл тавьж, оролцон ажиллав.





- Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоотой байгуулсан санамж бичгийн хүрээнд 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр тус холбооны гишүүн байгууллагуудын удирдлагатай уулзаж, Дэлхийн Худалдааны Байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн талаар хийсэн судалгааг танилцуулсан ба “Монгол Улсын тээвэр, логистикийн саад тотгорыг арилгах нь” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.



***Тайлбар:*** *2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр МҮХАҮТ-ын дэргэдэх Худалдааг хөнгөвчлөх, тээвэр логистикийн зөвлөлөөс “Худалдааг хөнгөвчлөх, тээвэр логистикийн салбарын хөгжилд төр, хувийн хэвшлийн оролцоо” сэдэвт уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулагдав.*

- Далайн захиргаанаас “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр болон хэлэлцээрээр олгогдож буй давуу талууд” сэдэвт илтгэл тавьж хэлэлцүүлэгт оролцлоо.

*Энэхүү илтгэлдээ Монгол Улсын импортын ачаа барааг гуравдагч орноос далайгаар тээвэрлэн хөрш орнуудын далайн боомтод авчрах, улмаар БНХАУ болон ОХУ-ын нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэх үед тулгардаг хүндрэл бэрхшээлийг арилгахад Дэлхийн худалдааны байгууллагаас батлан гаргасан Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр ямар ач холбогдолтой болохыг заалт тус бүрээр гарган харуулахыг зорьсон болно.*

# 3 Далайн тээвэр, боомт ашиглалтын чиглэлийн хамтын ажиллагаа:

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик, тээврийн сургуультай хамтран ажиллах тухай Санамж бичгийг 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдөр байгуулав.



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХАРЬЯА МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГАА

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН МЕХАНИК, ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

2019 оны 03 сарын 27-ны өдөр Дугаар 3МЕТ-AGR-005 Улаанбаатар хот

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Тээвэр, логистикийн салбарт үндэсний боловсон хүчнийг бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхижуулах зорилгоор нэг талаас Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа Далайн захиргаа, нөгөө талаас Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик, тээврийн сургууль (цаашид Талууд гэх) хамтран ажиллахаар тохиролцож энэхүү Санамж бичгийг байгуулав.

1.2. Талууд Монгол Улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд энэхүү "Хамтран ажиллах санамж бичиг"-ийг баримталж, ил тод нээлттэй байх, асуудлыг хамтран шийдвэрлэх, үр дүнг нэгтгэн хэлэлцэх, бие даасан байдлыг хангах, харилцан хүндэтгэлтэй хандах зарчмуудыг удирдлага болгон хамтран ажиллана.

**Хоёр. Талуудын хамтын ажиллагаа**

2.1. Механик, тээврийн сургуулийн Тээврийн менежмент мэргэжлийн Далайн тээвэр, боомтын үйл ажиллагаатай холбоотой хичээлийн сургалтын хөтөлбөрийг хамтран боловсруулна.

2.2. "Далайн тээвэр, боомтын үйл ажиллагаа" сонгон суралцах хичээлийн хүрээнд мэдлэг, чадварыг оюутнуудад эзэмшүүлнэ.

2.3. Тээвэр логистикийн салбар дахь төрийн болон төрийн бус байгууллага, Олон улсын байгууллагаас зохион байгуулагдах эрдэм шинжилгээний бага хурал, семинар, уулзалтад багш, эрдэмтэн судлаачдыг оролцуулах замаар шаардлагатай мэдээ, мэдээллийг олж авахад дэмжлэг үзүүлж ажиллана.

2.4. Оюутнуудын дунд мэргэжлийн баримжаа олгох уралдаан тэмцээн, эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулах, тээвэр логистик, эдийн засаг, санхүү болон бусад холбогдох салбарын туршлагатай мэргэжилтнүүдийг урьж хичээл заалгах, лекц уншуулахад хамтран ажиллана.

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН МЕХАНИК, ТЭЭВРИЙН СУРГУУЛИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Захирал:

Д. ЦОЛМОНБААТАР

Тус санамж бичигт тусгагдсаны дагуу "Далайн тээвэр, боомтын үйл ажиллагаа" сэдэвт E.TR 449 код бүхий сонгон суралцах 3 кредит цагийн хичээлийн хөтөлбөрийг боловсруулж, 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 24-ний өдөр хүртэл хугацаанд оюутнуудад зааж эзэмшүүлсэн.

## *Хамтын ажиллагааны хүрээ:*

*- "Далайн тээвэр, боомтын үйл ажиллагаа" сэдэвт хичээлийн хөтөлбөрийг боловсруулан оюутнуудад лекц, семинар хэлбэрээр эзэмшүүлэх.*

*- Төгсөх курсийн зарим оюутнуудын дипломын ажлыг удирдан оюутнуудад практик мэдээлэл олгож салбарт гарч ажиллахад бэлтгэх.*

*- Эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавих замаар далайн тээврийн салбарын өнөөгийн чиг хандлага, Монгол Улсын эдийн засагт үзүүлж болох нөлөөлөл, холбогдох үр дагаврыг таниулах.*

*- Салбарын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор бусад ангийн хичээл, семинарт зочин илтгэгчээр оролцох гэх мэт.*

# 4 Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр:

**“Усан замын тээврийн тухай” хуулийг хэрэгжүүлэх зорилгоор салбарын захиргааны хэм хэмжээний актуудыг шинээр боловсруулж, батлуулах ажлын хүрээнд:**

- “Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төлбөрийн жишиг”-ийг батлах тухай тогтоолын төслийг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 248 дугаар тогтоолоор батлуулсан.
- “Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам, сургалтын жишиг хөтөлбөр, үнэмлэхний загвар”-ыг Зам, тээврийн хөгжлийн сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 269/А/271 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан.
- “Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын стандарт, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах” ажлыг эхлүүлсэн.
- “Усан замын тээврийн салбарын хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлох, төрөөс усан замын тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулав.

# 4 Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр:

## Усан замын тээврийн салбарын боловсон хүчнийг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх ажлын хүрээнд:

- ОХУ-ын Онцгой байдлын яамны Байгаль нуурын эрэн хайх, аврах ангийн сургалтын төвд зохион байгуулагдсан “Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалт”-д Далайн захиргаанаас 2 мэргэжилтэн, улсын байцаагчийг хамруулж, гэрчилгээ аваад байна. /2019 оны 05 дугаар сарын 12-31-ний хооронд/
- ХБНГУ-д Аврах завь жолоодох, засвар үйлчилгээ хийх сургалтад ЗТХЯ-ны болон Далайн захиргааны мэргэжилтэн, улсын байцаагчдыг хамруулсан. /2019 оны 04 дүгээр сарын 04-15-ны хооронд/
- МХЕГ-аас тээврийн хяналтын улсын байцаагчдад зориулсан “Зөрчил хянан шийдвэрлэхтэй холбоотой хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгөх” сургалтад улсын байцаагчдыг хамруулсан. /2019 оны 03 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд/

**ОХУ-ын Онцгой байдлын яамны Байгаль нуурын эрэн хайх, аврах анги**







**ХБНГУ-ын Далайн эрэн хайх, авран туслах байгууллага**







# 4 Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр:

Аврах 2 завийг хөвөлтөд гаргах ажлыг ХБНГУ-аас уригдан ирсэн инженер, техникийн ажилтнуудын удирдлаган дор гүйцэтгэж, техникийн ашиглалтын зохих зааварчилгаа авах ажлыг Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд 2019 оны 06 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулсан.







# 4 Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр:

**“Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа” сэдэвт семинарыг 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулсан.**

**Оролцогч байгууллагууд:**

- Зам, тээврийн хөгжлийн яам,
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам,
- Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа,
- Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газар болон Онцгой байдлын газар,
- “Монгол Ус” ТӨААТҮГ,
- Хатгал тосгоны Захирагчийн ажлын алба,
- “Хөвсгөл далай ээж нийгэмлэг” ТББ,

Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн, усан замын тээврийн хэрэгслийн жолооч зэрэг нийт 100 орчим хүнийг хамруулж, “Усан замын тээврийн тухай” хууль, шинээр батлагдсан дүрэм, журмын танилцуулга, усан замын тээврийн салбарт авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, аюулгүй ажиллагааны заавар зөвлөмж өгөх илтгэл тавигдаж, тулгамдаж буй зарим асуудлын талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.






# 4 Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр:



**2019 онд улсын хэмжээнд нийт 156 усан замын тээврийн хэрэгслийг тооллогод хамруулсан.**

| Аймаг, орон нутгийн нэр | Хөвсгөл | Архангай | Улаанбаатар | Дархан-Уул | Орхон | Баян-Өлгий | Булган | Сэлэнгэ | Дорнод | Увс | Хэнтий | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Усан замын тээврийн хэрэгслийн тоо | 106 | 18 | 7 | 1 | 2 | 2 | 4 | 2 | 6 | 7 | 1 | 156 |
| Техникийн үзлэгт тэнцсэн | 72 | 14 | - | 1 | - | - | 3 | - | - | 6 | - | 96 |
| Техникийн үзлэгт тэнцээгүй | 7 | - | - | - | - | - | - | - | 4 | - | | 11 |
| Засвартай улмаас хөвөлтөд оролцоогүй | 17 | - | - | - | - | - | - | - | - | - | | 17 |
| Бусад шалтгаанаар үзлэгт хамрагдаагүй | 10 | 4 | 7 | - | 2 | 2 | 1 | 2 | 2 | 1 | 1 | 32 |

*2019 оны техникийн хяналтын үзлэгийн дүнгээр*

# 4 Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр:

**Улсын бүртгэлд 2019 онд гэрчилгээ, улсын дугаартай 145 тээврийн хэрэгсэл байна. Шинээр 26 тээврийн хэрэгслийг бүртгэж гэрчилгээ, улсын дугаар олгосон.**




Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 119 дүгээр тушаалаар усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээний загварыг шинэчлэн баталсантай холбогдуулан 99 тээврийн хэрэгсэлд шинэчилсэн гэрчилгээг олгох зохион байгуулсан.

- Усан замын тээврийн хэрэгсэл шинээр улсын бүртгэлд бүртгэсэн - **26**
- Усан замын тээврийн хэрэгсэлд шилжилт хөдөлгөөн хийсэн - **7**
- Бүртгэлээс хасч, гэрчилгээг хүчингүй болгосон - **3**

# 4 Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр:

**Усан замын тээврийн хяналтын чиглэлээр**

- Усан замын тээврийн аюулгүй байдлыг шалгах ”Хяналтын хуудас”-ыг шинэчлэх санал боловсруулж, МХЕГ-ын Даргын 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/25 дугаар тушаалаар батлуулсан.

- Далайн захиргааны даргын 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдөр баталсан “Хяналт, шалгалт хийх тухай” 38-07-047/31 тоот удирдамжийн дагуу Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд усан замын тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн.

  - ✓ *Хяналт, шалгалтад 4 аж ахуйн нэгж, 5 иргэнийг хамруулсан.*
  - ✓ *Нийт 56 зөрчил илрүүлсэн.*
  - ✓ *Зөрчлийг арилгуулах талаар дээрх аж ахуйн нэгж, иргэдэд улсын байцаагчийн зөвлөмж, албан шаардлагыг хүргүүлсэн.*



**№5.23.УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

**Хяналтын байгууллага:**
**Шалгуулагч этгээдийн нэр:**
**Объектын нэр:**
**Регистрийн дугаар:**

Хяналт шалгалт хийсэн огноо: …./../..

Шаардлага хангасан асуултын тоо: | Хууль сахин мөрдөлтийн хувь:
Шаардлага хангаагүй нийт оноо: | Эрсдэл үүсэх магадлалын хувь: | Эрсдэл үүсэх магадлал

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ**

| № | Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт | Асуултууд | Батлагдсан оноо | | Авсан оноо | Гүйцэтгэл-ийн шалгалт |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Шаардлага хангасан | Шаардлага хангаагүй | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | “Усан замын тээврийн тухай хууль”-ийн 9.1 | Усан замын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан | | | | |
| 2 | “Усан замын тээврийн тухай хууль”-ийн 8.1-8.3 | Усан замын тээврийн хэрэгслийг эзэмшигч нь усан тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн захиргааны байгууллагад бүртгүүлж, бүртгэлийн гэрчилгээ авсан. | 0 | 10 | | |
| 3 | “Усан замын тээврийн тухай хууль”-ийн 8.6 “Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын 7.2 | Усан замын тээврийн хэрэгслийн нэр, улсын дугаарыг тээврийн хэрэгслийн үзэгдэх орчны хэсэгт дэвсгэр өнгөнөөс ялгагдах тод өнгөөр тэмдэглэсэн ба баталсан загварын дагуу байршуулсан. | 0 | 3 | | |
| 4 | “Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын 7.4 | Усан замын тээврийн хэрэгслээ товлогдсон хугацаанд техникийн хяналтын үзлэгт заавал хамруулсан. | 0 | 10 | | |

*Хуудас 1*

# 4 Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр:

**Хөвсгөл нуурын гүн, ёроолын зураглал, усан замын навигацийн зураг хийх туршилтын хэмжилт, судалгааны ажлыг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллав.**










# 4 Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр:

**Усан замын тээврийн хяналтыг сайжруулах талаар хэрэгжүүлсэн ажилууд:**

***<u>2018 онд Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд:</u>***

Усан замын тээврийн хэрэгслийн техникийн үзлэг, оношлогооны төв болон аврах завь хадгалах, засвар үйлчилгээ хийх зориулалттай өвлийн битүү зогсоол, цахилгаан эрчим хүчний шугам, ариун цэврийн байгууламж, гадна тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.







***<u>2019 онд Хөвсгөл аймгийн Ханх суманд:</u>***

Усан замын тээврийн “Хяналтын пост”-ыг шинээр барьж байгуулах барилга бүтээн байгуулалтын ажлыг хийгээд байна.











# 4 Усан замын тээврийн бүртгэл, хяналтын чиглэлээр:

**Усан замын тээврийн хэрэгслийг хянах, онцгой нөхцөлд шуурхай харилцаа, холбоо тогтоох техник, тоног төхөөрөмж талаар судалгааг хийв.**

***G-Mobile сүлжээний тархалт***




Сүлжээний чанар нь ногооноос улаан руу чиглэсэн уусан өнгөөр оруулав.

- Ногоон өнгө- маш сайн
- Шар өнгө- сайн
- Шаргал өнгө-дунд зэрэг
- Улаан өнгө-муу




***Бусад сүлжээний тархалт***






# 5 Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр:







Олон улсын далайн байгууллагын Ерөнхий Ассамблейн 31 дэх удаагийн ээлжит чуулганд Монгол Улсын далайн салбарын бодлого, үйл ажиллагааны талаар танилцуулж, ОУДБ-ын Зөвлөлийн сонгуульд ГХЯ-наас өгсөн чиглэлийн дагуу санал өгч оролцов.

БНСУ-ын Сөүл хотноо зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүс нутгийн Далайн тээврийн аюулгүй байдлын агентлагуудын дарга нарын 20 дугаар чуулга уулзалтад анх удаа албан ёсны гишүүн байгууллагын байр суурьнаас оролцож, зөвлөгөөний үеэр явагдсан хэлэлцүүлгүүдэд саналаа илэрхийлэв.

# ХАБЭА-н чиглэлээр авч хэрэгжүүлсэн зарим ажлууд

**Далайн захиргааны хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны хяналтыг зохион байгуулах журам**

**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгөх тухай журам**

**Усан замын тээврийн хяналтын катер болон аврах завины техникийн ашиглалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх журам**



# ХАБЭА-н чиглэлээр авч хэрэгжүүлсэн зарим ажлууд

## Байгууллагын ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийг байгуулж, 2019-2020 оны ажлын төлөвлөгөөг батлав.

**Далайн захиргааны ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн ажиллах журам, түүний чиг үүрэг**

**Далайн захиргааны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн зорилго нь** байгууллагын түвшинд ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

- ХАБЭА-н хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах
- Хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм журмын санал боловсруулж батлуулах
- Зөвлөгөөн, сургалт семинар зохион байгуулах
- Санал, зөвлөмж гаргах
- Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үзлэг шалгалт хийх
- Хууль тогтоомжид заасан бусад асуудал

**Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын бүрэлдэхүүнийг томилсон**

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тохиолдолд осол хордлогын шаалтгааныг тогтоох, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг байгуулж бүрэлдэхүүнийг баталсан.

# ХАБЭА-н чиглэлээр авч хэрэгжүүлсэн зарим ажлууд



# ХАБЭА-н чиглэлээр авч хэрэгжүүлсэн зарим ажлууд

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хэрэгжилтийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын талаар туршлага солилцох, мэдлэг хуваалцах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа байгууллагууд, аж ахуйн нэгжүүд /ажил олгогч/, мэргэжлийн холбоод, Үйлдвэрчний эвлэл, ажилтнуудын төлөөллийн дунд 2019 онд холбогдох арга хэмжээг дараах байдлаар зохион байгуулсан билээ. Үүнд:

- “Улаанбаатар төмөр зам” ХНН-ээс 2019 оны 04 дүгээр сард,
- Иргэний нисэхийн ерөнхий газраас 2019 оны 06 дугаар сард,
- Автотээврийн үндэсний төвөөс 2019 оны 09 дүгээр сард,
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ дээр 2019 оны 10 дугаар  сард

Дээрх арга хэмжээнүүдэд Далайн захиргаанаас холбогдох албан тушаалтныг тогтмол оролцуулж байсан бөгөөд 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-тай хамтран туршлага солилцох уг арга хэмжээг зохион байгуулсан.






# Албан хаагчдын чөлөөт цагийг идэвхитэй, хөдөлгөөнтэй, зөв боловсон өнгөрүүлэх спортын өдрүүдийг аяны хугацаанд зохион байгуулах

Ажилтны ажлын стресс, ядаргаа тайлах, чийрэгжүүлэн хөгжүүлэх, байнгын дасгал хөдөлгөөнтэй, эрүүл байлгах зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор спорт заалыг 7 хоног бүрийн Даваа гарагт түрээслэж, ажилтнуудыг идэвхитэй хамруулж байна.

Мөн энэ оны 04 дүгээр сарын хугацаанд Зам, тээврийн салбарын тэмцээний спортын төрөл бүрээр бэлтгэл хийх ажлыг зохион байгуулсан бөгөөд ажилтнууд тэмцээнд идэвхитэй оролцсон болно.












# ХАБЭА-н чиглэлээр авч хэрэгжүүлсэн зарим ажлууд

- Усан замын тээврийн хяналтын улсын байцаагч болон далбааны эзэн улсын хянан шалгагч нарыг шаардлагатай хувцас, багаж, техникийн хэрэгсэл, ажлын нөхцөлөөр ханган ажиллаж байна.
- Усан замын тээврийн хяналтын улсын байцаагч хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүднээс “Хяналтын катер ашиглах техникийн заавар”, “Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм”, “Усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрэм”-ийг мөрдөн ажиллаж байна.
- Усан замын тээврийн Хяналтын байрыг шинэчлэн тохижуулсан.






















# Анхаарал хандуулсанд баярлалаа

**ДАЛАЙН ЗАХИРГАА**


Утас: +976-11 261489
+976-11 261490

Факс: +976-11 310642

И-мэйл: info@monmarad.gov.mn

Цахим хуудас: www.monmarad.gov.mn